

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.8 дугаар зүйлд мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох асуудлыг зохицуулсан бөгөөд уг зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох...”, 5 дахь хэсэгт “Хавтаст хэрэгт тусгагдаагүй...мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн, бусад баримт болон гүйцэтгэх ажилтай холбоотой ямар ч баримт мэдээллийг шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг явуулах, хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд танилцуулахыг хориглоно” гэж тус тус хуульчилсан.

Мөн хуулийн 32.1 дүгээр зүйлд хэргийн оролцогч нарт хавтаст хэргийн материал танилцуулах ажиллагааг тусгаж, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Оролцогч хүсэлт гаргавал хавтаст хэргийн материалаас шүүхээр хэлэлцүүлэх төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах боломжоор хангана. Талууд хуулбарлан авсан нотлох баримтыг шүүхэд шинжлэн судлахаас өөр зорилгоор ашигласан бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан.

Албаны нууцад хамаарч байсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн, холбогдох баримт сэлт ил болох тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “...нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж” задрах эрсдэлийг дагуулахын зэрэгцээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогч нарт төрийн нууцаас бусад нотлох баримтыг хуулбарлан олгох нь мөрдөн шалгах нууц ажиллагааны нууцлал, аюулгүй байдал алдагдах эрсдэлийг бүрдүүлэхээр байна.

Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд тэгш эрхтэй мэтгэлцэх, хавтаст хэргийн материалыг хуулбарлан авах эрхийг хангахын зэрэгцээ мөрдөн шалгах нууц ажиллагааны аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлага үүсэж байна.

Энэ хүрээнд мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг бэхжүүлсэн баримтаас холбогдох хэсгийг нууцалж гардуулах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлтээр тусгах нь зүйтэй байна. Ингэснээр мөрдөн шалгах нууц ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалжийг хамгаалах, оролцогч талуудын амь нас, аюулгүй байдлыг хангах, цаашлаад эрүүгийн процессын шударга, найдвартай байдлыг баталгаажуулах чухал ач холбогдолтой.